

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Нийслэлийн Засаг даргын 2023 оны Нийслэлийн “2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” А/817 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, төлөвлөсөн ажлаа эрчимжүүлж ажиллах.				
1	<p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын А/253 дугаар захирамжаар 55 хүний бүрэлдэхүүнтэй өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулагдаж, дүүргийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 12 салбар 125 заалттай төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2023 оны 07 дугаар сарын байдлаар өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 70,3 хувьтай байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийтлэг үйлчилгээний газар -85 хувь 2. Боловсролын хэлтэс - 65 хувь 3. Онцгой байдлын хэлтэс – 54,5 хувь 4. Эрүүл мэндийн төв – 75,1 хувь 5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв - 85 хувь 6. ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6 -41 хувь 7. ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7 -39 хувь 8. “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК -91,6 хувь 9. “Найши трейд” ХХК -80 хувь 10. “Соёндрийм” ХХК -70,5 хувь <p>Хувийн халаалтын уурын зуухнууд:</p> <ol style="list-style-type: none"> 11. Ану сервис” ХХК -83 хувь 12. “Элбэг дулаан” ХХК-75 хувийн хэрэгжилттэй байна. 			70
Үүрэг даалгавар ХОЁР: Төр, хувийн хэвшлийн халаалтын зуух, барилга байгууламжийг төвлөрсөн дулаан, цахилгаан, хий болон бусад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжүүлэх ажлаа эрчимжүүлж ажиллах.				
2	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв өвөлжилтийн бэлтгэл хангах ажил 85 хувьтай.			70

	<p>2023 онд хийгдсэн засварын ажлаар 600 тоолуурын нэгдсэн хайрцагт ашиглалт сайжруулах засварын ажил хийгдэхээс 510 тоолуурын нэгдсэн хайрцагт засвар хийгдсэн. Техник зохион байгуулалтын арга хэмжээгээр 1,6 метрээс өндөрт байрлалтай 15 тоолуурын нэгдсэн хайрцаг буулгах ажил хийгдсэн.</p> <p>Давхардсан тоогоор нийт 5270 тоолуурын нэгдсэн хайрцагт үзлэг хийгдсэн.</p> <p>Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6</p> <p>Өвөлжилтийн бэлтгэл хангах ажил 41 хувьтай. Чингэлтэй дүүргийн 4, 5, 6, 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 110 байр, 645 аж ахуй нэгж байгууллагын халаалт, халуун хүйтэн усыг түгээж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7</p> <p>Өвөлжилтийн бэлтгэл хангах ажил 39 хувьтай. Чингэлтэй дүүргийн 1, 2, 3 дугаар хорооны 96 байрны 3405 өрх, 867 аж ахуй нэгж байгууллагын халаалт, халуун хүйтэн усыг түгээж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>“Ану сервис” ХХК, “Элбэг дулаан” ХХК зэрэг хувийн халаалтын уурын зуухнууд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Ану сервис” ХХК өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 83 хувьтай. 57, 17, 49, 72-р сургууль, 56, 102, 86-р цэцэрлэгийн халаалтыг хариуцаж ажилладаг. Чех улсад үйлдвэрлэгдсэн хатуу шингэн түлшээр ажилладаг “Dakon” маркийн 2 ш зуухтай ажиллаж байна.</p> <p>“Элбэг дулаан” ХХК өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 75 хувьтай. 18 дугаар хорооны цогцолбор, 37-р сургууль, 103, 247-р цэцэрлэг, “Дэлхийн зөн” ОУБ халаалтыг хариуцаж ажилладаг. БНСУ-д үйлдвэрлэгдсэн хатуу шингэн түлшээр ажилладаг N1.8, DZL 1.8 маркийн 2 ш зуухтайгаар тус тус ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг даалгавар ГУРАВ: Нийслэлийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлэг, хяналтын камер, кабель, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн засварлах ажлаа эрчимжүүлж ажиллах.</p>				
3	<p>Чингэлтэй дүүргийн “Соён дрийм” ХХК засварын 4 бригадын нийт 12 хүн, 7 хоногийн 6 өдөр бүтэн цагаар, шөнийн шуурхай дуудлагын жижүүр, амралтын 1 өдрийн шуурхай дуудлагын жижүүр гаргаж 4 өргөгчтэй авто крантай бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж байна. Гэрэлтүүлгийн гэмтэлтэй холбоотой өргөдөл гомдлыг тухай бүрд биелүүлж, гомдол дуудлагыг нарийн графикт оруулан дарааллын дагуу түргэн шуурхай очиж засварлаж, ШУЗТ, ЧД-ийн гомдол хүлээн авах веб хуудсанд засварласан зургийг баталгаажуулан илгээдэг. Хуваарьт цагийн дагуу хөдөлгөөн хязгаарлагдмал үед ЧД-ийн нийт зам, гудамж талбай, гэр хорооллын гэрэлтүүлгийн асалт, цахилгааны утас унжсан, ил задгай байгаа эсэх, шонгийн тагжуулалт бүрэн бүтэн байгаа эсэхэд үзлэг шалгалт хийн хяналт тавьж, гарсан зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүрд зөрчлийг арилган ажиллаж байна. Мөн ойрын өдрүүдэд тохиогоод байгаа үер усны гамшгийн эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж болзошгүйтэй холбогдуулан хүн хүчээ шаардлагатай хувцас хэрэгслээр ханган, авто техникийн байнгын бэлэн байдалд ажиллаж байна. Нийт 7 сард 10 удаагийн өргөдөл гомдлыг бүрэн шийдвэрлэн ажилласан.</p>			70
<p>Үүрэг даалгавар ДӨРӨВ: 2023-2024 оны халаалтын улиралд хэрэглэх сайжруулсан түлшний нөөцийн агуулахыг бэлтгэн, нөөц бүрдүүлэх, борлуулалтын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах.</p>				

4	<p>Агаарын бохирдол болон ногоон байгууламжийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил: Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, 2020 оны 189 дүгээр тогтоол, нийслэлийн засаг даргын ажлын хэсэг байгуулах тухай А/779 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн 7-24 дүгээр хороо буюу гэр хорооллын бүсэд нийт 90 сайжруулсан түлш борлуулах цэг, 5 нөөцийн агуулах ажилласан.</p> <p>2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт 8 агуулах, 4 саравчинд 14,000 тонн сайжруулсан шахмал түлшийг нөөцлөхөөр бэлтгэл ханган ажиллаж байна.</p> <p>Мөн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт 100 сайжруулсан түлш борлуулах цэгийг ажиллуулж байна.</p>			90
<p>Үүрэг даалгавар ТАВ: Авто зам, замын байгууламж, гүүрэн болон нүхэн гарц, хайс хашлагийн цэвэрлэгээ үйлчилгээ, засвар арчлалтын ажлыг тогтмол хийж, аюулгүй байдлыг хангаж ажиллах.</p>				
5	<p>Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК орон сууцны 1-6 дугаар хороодын хорооллын дундах 815,000м2 зам талбайгаас 29 рейс, 217,5 тн лаг, шавар шороо, явган болон авто замын цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэж байна. Дүүргийн Самбуугийн гудамжинд бу/м эвдэрсэн хашаа засварын ажлыг хийж гүйцэтгэлээ.</p>			90
<p>Үүрэг даалгавар ЗУРГАА: Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах, авто замын шар тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, анхааруулагч, санамж бүхий тэмдэгүүдийг 09 дүгээр сарын 01-ны дотор байршуулж, засварлаж дуусгах.</p>				
6	<p>Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчийн нийт сургууль цэцэрлэгүүд : 2023-2024 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ 49-р сургууль явган хүний гарц дээр хүүхдийн гарцаар гарах тэмдэглэгээг сэргээж, шинээр камер нэмж байршуулах сургуулийн дотор камерыг засах , хичээлийн А байранд галын дохиолол тавих, хонхыг шинээр сольсон, сургууль орчмын замын тэмдэг тэмдэглэгээ, явган хүний гарц, сургуулийн бүс тэмдэглэгээ, зогсоолын тэмдэглэгээг зуун хувь иж бүрэн, хийж дуусгасан. 			30
<p>Үүрэг даалгавар ДОЛОО: Үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээ үйлчилгээ болон засвар шинэчлэлтийн ажлыг батлагдсан графикийн дагуу хийж гүйцэтгэн, үер усны аюулаас тогтмол урьдчилан сэргийлж ажиллах.</p>				
7	<p>Дүүргийн:</p> <ul style="list-style-type: none"> ➢ 19, 24 дүгээр хороо, Сэлбэ голын дагуух үерийн хамгаалалтын далангийн эвдрэл гэмтэл, ➢ 8 дугаар хороо, Тасганы овооны бороо, үерийн ус зайлуулах сувгийн эхлэл хэсгийг засварлуулах, ➢ 7 дугаар хороо, Зурагтын эцсийн буудлын авто замын доорх бороо, үерийн ус зайлуулах гаргалгааг Геодези, усны барилга байгууламжийн газраар цэвэрлүүлэн ажиллаж байна. ➢ 16 дугаар хороо, Согоот 43-р гудамжны бороо, үерийн ус зайлуулах сувагт хуримтлагдсан лаг, шаврыг цэвэрлэж ажлыг “Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ” ХХК-р гүйцэтгүүлэн ажиллаж байна. Гэр хороолол төвийн хороодын далан суваг, гуу жалганы лаг цэвэрлэгээг тогтмол гүйцэтгэн ажиллалаа. Үерийн улмаас хуримтлагдсан байршлууд болох нийт 215,355м2 талбайн хог хаягдлыг цэвэрлэн ажилласан. Дүүргийн 16-р хороонд үерийн ус 			70

	зайлуулах шуудууг сэргээх, үерийн усаар урсан орсон шороог механизмаар сэргээх ажлыг хийж гүйцэтгэлээ.			
Үүрэг даалгавар НАЙМ: <i>Үерийн аюулын улмаас учирсан хор уршигт дүн шинжилгээ хийх, эвдэрсэн авто зам, явган зам талбайг засварлах, зам дээр тогтсон усыг соруулах, сүвээглэх, цэвэрлэх, ариутгаж халдваргүйжүүлэх ажлууд эрчимжүүлж ажиллах.</i>				
8	Гамшгийн хор уршигт дүн шинжилгээ хийж, учирсан хохирлыг тогтоох дэд ажлын хэсэг 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдөр байгуулагдсан. Тус ажлын хэсэг 2 удаа хуралдаж, гамшгийн хохирлын урьдчилсан судалгааг илтгэх хуудастай Нийслэлийн Онцгой комисст хүргүүлэн ажилласан. Гамшгийн хохирлын судалгааг 07 дугаар сарын 26-ны өдөр хороодын Засаг дарга нараас авч нэгтгэн Ажлын хэсгийн даргад танилцуулж ажилласан.			70
Үүрэг даалгавар ЕС: <i>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/838 дугаар захирамжийн дагуу үерийн шалтгаан, нөхцөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг шаардлагатай мэдээ, мэдээллээр шуурхай хангаж ажиллах.</i>				
9	<p>Дүүргийн 19, 24 дүгээр хорооны үерийн аюулд өртөж болзошгүй иргэдэд урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжийг Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн бэлтгэл ээлжийн 15 алба хаагч, Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн 4 сонсогч, Toyota Naice маркийн автомашинтай үерийн эрсдэлтэй бүсэд байршилтай 120 өрхийн 162 иргэнд брошур материал болон мэргэжлийн заавар зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, постер, шторк бэлтгэн дүүргийн 1-24 дүгээр хорооны дотор байрлах дэлгэцүүдээр давтагдсан тоогоор 120 удаа, хэлтсийн фэйж хуудас болон chd.nema.gov.mn сайтад нийт 42 мэдээ, байршуулан нийт 12304 иргэнд хүргэн ажиллаж байна.</p> <p>Чингэлтэй дүүргийн Нийслэлийн засаг захиргааны III байрны лед дэлгэц, MN Tower төвийн гадна талбайн лед дэлгэц, дүүргийн 7-24 дүгээр хорооны цахим дэлгэц, Алтжин бөмбөгөр худалдааны төвийн цахим дэлгэцээр тус бүр өдөрт 5-6 удаагийн давтамжтайгаар нийт 16 удаа хүргэж сурталчилж ажилласан.</p> <p>Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, үүрэг гүйцэтгүүлэх тухай” А/59 дүгээр тушаалаар Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Ангиллын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч гал сөнөөгч, ахлах ахлагч М.Мөнхжаргал, Ангиллын сургалт сурталчилгаа, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан мэргэжилтэн, дэслэгч С.Урантөгс 2023 оны 07 дугаар сарын 12, 16-ны өдрүүдэд Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 6 албан хаагч, 1 автомашин, давхардсан тоогоор нийт 12 албан хаагч, 2 автомашинтай, 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс 21-ний өдрийн хугацаанд Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 6 албан хаагч, 1 автомашин, давхардсан тоогоор нийт 30 албан хаагч, 5 автомашинтай хамтран Нийслэлийн Онцгой байдлын газраас гаргасан усны ослоос урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлээр Яармагийн гүүрнээс Маршалын гүүр хүртэлх 6.2 км газарт эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Эргүүлээр маршалын гүүрний доор амарч зугаалж байгаа нийт 77 иргэн, 44 хүүхдэд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх</p>			70

	<p>заавар зөвлөмж хүргэн ажилласан. Мөн тус хэлтсээс дүүргийн 19-24 дүгээр хороонд байрлах Сэлбэ гол болон Туул голын усанд иргэдийг осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дрон /Нисгэгчгүй нисэх төхөөрөмж/-ыг ашиглан агаараас нийт 42 удаагийн нислэгээр 116 км газарт иргэдийн хөдөлгөөнд тандалт хийж зураг болон бичлэг хийн дүрсжүүлэн ажилл Нийслэлийн Онцгой байдлын газрын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн гаргасан Дүүргийн хэмжээнд 7 дугаар сард Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахтай холбогдуулан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын ажилтан алба хаагч, гамшгаас хамгаалах томилгоот бүрэлдэхүүн, иргэдэд гамшгаас хамгаалах 1 цагийн сургалтыг 2023 оны 07 дугаар сарыг 17-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хугацаанд “Бэлэн бай” багцын “Гал түймэр”, “Газар хөдлөлт” сэдвээр нийт 72 ажилтан алба хаагч, 120 иргэнд зохион байгуулан ажилласан.</p> <p>Улаанбаатар хотод ширүүн болон усархаг бороо орсны улмаас дүүргийн 19, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах сэлбэ голын эргээс хальж олон тооны айл өрхийн гэр болон хашаа байшинд үерийн ус нэвтэрч орсныг дүүргийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн 262 албан хаагч, 9 механизм, 20 ачааны автомашинтайгаар 2023 оны 7 дугаар сарын 04-ээс 07-ны өдрүүдэд дүүргийн 19, 24 дүгээр хорооны үерийн усанд өртсөн 273 өрхийн 650 гаруй иргэний аюулгүй байдлыг ханган 1.5км-ийн урттай даланг 156 машин шороо асгаж, хүчитгэх ажлыг шуурхай зохион байгуулан ажилласан.</p> <p>Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 41 албан хаагч 5 тээврийн хэрэгсэл, Цагдаагийн газрын 35 албан хаагч 3 тээврийн хэрэгсэл, ЗДТГ-ын Цэргийн штабын 5 албан хаагч, дүйцүүлэх 13, 1 тээврийн хэрэгсэл, “Тохижилт үйлчилгээний” ХХК-ийн 45 албан хаагч, 1 ковш, 1 экскаватор, 15 ачааны машин, “Наши трейд” ХХК-ийн 19 албан хаагч, 1 экскаватор, 5 ачааны машин, ЗДТГ, хороодын ажлын албаны 104 албан хаагч, 3 тээврийн хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэн ажилласан.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрт үерийн усанд автсан зоорины давхрын барилга байгууламжийн судалгааг 3/1860 тоот албан бичгээр Хотын стандарт, хяналтын газарт хүргүүлэн ажилласан.</p>			
<p>Үүрэг даалгавар АРАВ: Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын явц, үр дүнг танилцуулах.</p>				
10	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр баталсан “Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах тухай” удирдамжийн дагуу 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар, Нийслэлийн Аялал, жуулчлалын газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, дүүргийн Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хамтран худалдааны төв, хүнсний болон хүнсний бус үйлдвэрлэл, амралтын газар, зочид буудал, дэн буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдэд хяналт хийж, хэрэгжилтийг ханган ажилласан.</p>			90

Үүрэг даалгавар АРВАН НЭГ: Төрийн захиргааны байгууллагууд, их дээд сургуулиуд болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайг тохижуулах, ногоон байгууламж байгуулах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

	<p>Нийслэл Улаанбаатар хотод 2023 оны 07 дугаар сарын 23-ний өдөр үргэлжлэн орсон аадар борооны улмаас үүсэн үертэй холбоотойгоор Чингэлтэй дүүргийн засаг даргын өгсөн үүргийн хүрээнд: ЕБ-н 19 сургууль, 39 цэцэрлэгийн тулгамдсан асуудал болон цаг үеийн байдлын талаар мэдээллийг сонсох цахим хуралдааныг 2023 оны 07 дугаар сарын 24 ний өдрийн 15, 16 цагуудад хуралдуулж захирал, эрхлэгч нар оролцсон ба тус хуралдаанаар өгсөн үүргийн дагуу сургууль, цэцэрлэгийн өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайг тохижуулах, ногоон байгууламж байгуулах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх чиглэлийн хүрээнд сургалтын байгууллагын эзэмшил газруудын талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, ногоон байгууламжийн /3425м/ усалгаа арчилгааг тогтмол хийж хөл газрын ургамал устгах, хог ачуулах, гадна дотор талбай, хашааг угааж цэвэрлэсэн.</p> <p>Дүүргийн 1-24 дүгээр хороод тус бүр өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайг, талбайг тохижуулах, ногоон байгууламж байгуулах чиглэлийн хүрээнд :</p> <ul style="list-style-type: none"> ➢ 49 дүгээр сургуулийн гадна талбайд 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулахаар хэмжилт хийн бэлтгэл ажил эхэлсэн. ➢ 57-р сургууль: Сургуулийн гадна фасадын засварын ажил 86 хувийн гүйцэтгэлтэй байна. 292-р цэцэрлэг: НБГ-аас хэрэгжүүлж буй “Хайлаасан төгөл” төсөлд хамрагдаж, 50м2 талбайд хайлаасны үр суулгаж, ногоон байгууламж нэмэгдүүлж ажиллаж байна. Цэцэрлэгийн ногоон байгууламжийн 1050м2 мод суулгац тарьсан газрыг тогтмол арчилж байна. ➢ 17 дугаар сургуулийн баруун талын цэвэр усны худгийн дотор цэвэрлэж, таг үер болон машин дээгүүр нь явсны улмаас эвдэрснийг шинээр сольж ажилчдын хамт засварлав. Өвөлжилтийн бэлтгэл хангаж Б байрны 00-д урсгал засвар хийж А байрны гэрэлтүүлэг шинэчлэв. ➢ 5 дугаар сургуулийн А байрны 2 ба 3 давхрын 00-ын засвар төслөөр хийгдэж байна ➢ 20 дугаар хороо Засаг дарга З.Очир-Бат Тохижилт үйлчилгээ ХХК-н ажилчидтай хамтран цэцэрлэгийн урд талын замыг хайрга асган, тэгшилж, индүүдэн зассан. 			90
--	--	--	--	----

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.БАЯРМАА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Т.ТҮВШИНЖАРГАЛ